

Лекц 3, 4. САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУД



СЭДВИЙН ЗОРИЛГО:

Санхүүгийн байгууллагуудын төрөл, хэлбэр, зорилго, эрхлэх үйл ажиллагааны талаар нэгдсэн ойлголт өгөх

СЭДВИЙН АГУУЛГА:

- 1. Санхүүгийн байгууллагуудын төрөл, ангилал**
- 2. Банкны байгууллага, түүний төрөл, онцлог**
- 3. Банк бус санхүүгийн байгууллагууд, тэдгээрийн төрөл, онцлог**


ТҮЛХҮҮР ҮГС

- Санхүүгийн байгууллага- **Financial Institution**
- Төв банк- **Central Bank**
- Арилжааны банк-**Commercial bank**
- Банк бус санхүүгийн байгууллага- **Nonbank Financial institution**
- Хадгаламж зээлийн хоршоо- **Savings and loan association**
- Хөрөнгө оруулалтын банк- **Investment bank**
- Хөрөнгө оруулалтын сан- **Investment fund**
- Хөрөнгийн бирж-**Stock exchange**
- Тэтгэврийн сан-**Pension fund**
- Даатгалын компани- **Insurance company**

1. САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨРӨЛ, АНГИЛАЛ

ТОДОРХОЙЛОЛТ:

Нэг буюу түүнээс дээш санхүүгийн үйлчилгээг голлон эрхэлж, эдийн засаг дахь мөнгөн харилцааг зохицуулж байдаг хуулийн этгээдийг санхүүгийн байгууллага гэнэ.



1. САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨРӨЛ, АНГЛАЛ



2. БАНКНЫ БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ТӨРӨЛ, ОНЦЛОГ

ТОДОРХОЙЛОЛТ:

- ✓ Сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг хадгаламж хэлбэрээр төвлөрүүлж, зээл олгох, төлбөр тооцоо хийх зэрэг санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг санхүүгийн зуучлагч байгууллагыг **банк** гэнэ.
- ✓ Хувьцаа эзэмшигчдийн оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдсэн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, хувьцаа эзэмшигч нь эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээдэг, бусдын мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хадгалж, өөрийн нэрийн өмнөөс зээл олгох, төлбөр тооцоо хийх зэрэг санхүүгийн зуучлалын үйл ажиллагааг Монголбанкны тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлдэг, ашигийн төлөө хуулийн этгээдийг **банк** гэнэ.

2. БАНКНЫ БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ТӨРӨЛ, ОНЦЛОГ

Банкны бусад байгууллагаас ялгагдах онцлог:

- Үйл ажиллагаа нь маш өргөн хүрээг хамардаг
- Төрийн мөнгөний бодлого банкаар дамжин хэрэгждэг
- Төрийн зүгээс тавих хяналт хүчтэй
- Харилцан итгэлцэл дээр үйл ажиллагаа нь үндэслэдэг
- Бусдын хөрөнгөөр үйл ажиллагаа явуулдаг.



2. БАНКНЫ БАЙГУУЛЛАГА: ТӨВ БАНК, ТҮҮНИЙ ТӨРӨЛ, ОНЦЛОГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

ТОДОРХОЙЛОЛТ:

- ✓ Төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагыг төв банк гэнэ.
- ✓ Төв банк нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангах, түүнчлэн санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй, тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилготой байдаг.



2. БАНКНЫ БАЙГУУЛЛАГА: ТӨВ БАНК, ТҮҮНИЙ ТӨРӨЛ, ОНЦЛОГ



ТОДОРХОЙЛОЛТ:

- ✓ Эдийн засгийн тодорхой хүрээнд бие даасан үйл ажиллагаа явуулж, мөнгөний бодлогын зорилго чиглэлийг өөрөө тогтоодог бол **засгийн газраас хараат бус** төв банк гэнэ.
- ✓ Засгийн газрын боловсруулсан мөнгөний бодлогыг хэрэгжүүлж, түүний удирдлага дор ажилладаг бол **засгийн газраас хараат төв банк** гэнэ.



2. БАНКНЫ БАЙГУУЛЛАГА: ТӨВ БАНК, ТҮҮНИЙ ТӨРӨЛ, ОНЦЛОГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

ТӨВ БАНКНЫ ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

- ✓ Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах;
- ✓ Мөнгөний бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;
- ✓ Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх;
- ✓ Банкны үйл ажиллагаанд хяналт тавих;
- ✓ Банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах;
- ✓ Гадаад валютын улсын нөөцийг эзэмшиж, удирдах.




2. БАНКНЫ БАЙГУУЛЛАГА: ТӨВ БАНК, ТҮҮНИЙ ТӨРӨЛ, ОНЦЛОГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

ТӨВ БАНКИНД ХОРИГЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

- ✓ Иргэн хуулийн этгээдэд санхүүгийн буцалтгүй тусламж үзүүлэх
- ✓ Ашиг олох зорилгоор хөрөнгө худалдах, худалдан авах
- ✓ Засгийн газар болон банкнаас бусад иргэн хуулийн этгээдэд банкны үйлчилгээ үзүүлэх
- ✓ Хуулийн этгээдийн дүрмийн санд хувь оруулах, үнэт цаас худалдан авах, худалдах



2. БАНКНЫ БАЙГУУЛЛАГА: ТӨВ БАНКНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



Монгол банкны газар
хэлтсүүд:

- Тамгын газар
- Мөнгөний бодлого, судалгааны газар
- Дотоод аудитын газар
- Хяналт шалгалтын газар
- Валют, эдийн засгийн газар
- Төлбөр тооцоо, бүртгэлийн газар
- Мэдээллийн Технологийн газар
- Санхүүгийн мэдээллийн алба
- Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл
- Банкны сургалтын төв
- Эрсдэлийн удирдлагын алба

2. БАНКНЫ БАЙГУУЛЛАГА: АРИЛЖААНЫ БАНК, ТҮҮНИЙ ТӨРӨЛ, ОНЦЛОГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

ТОДОРХОЙЛОЛТ:

- ✓ Бусдын мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хадгалж, өөрийн нэрийн өмнөөс зээл болгон олгодог ашигийн төлөө бизнесийн байгууллагыг арилжааны банк гэнэ.
- ✓ Банкны гол зорилго нь хувь нийлүүлэгчдийн хөрөнгийг арвижуулах буюу ашиг олох явдал байдаг.
- ✓ Монгол улсын банкны тухай хуульд “Хувь нийлүүлэгчийн оруулсан хөрөнгөөр бүрдсэн дүрмийн сантай, хувь нийлүүлэгчид нь оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр санхүүгийн хариуцлага хүлээдэг, бусдын мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хадгалж, өөрийн нэрийн өмнөөс зээл олгох, төлбөр зэрэг зуучлалын ажил үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг Монгол банкны тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлдэг ашигийн төлөө хуулийн этгээдийг банк гэнэ.

2. БАНКНЫ БАЙГУУЛЛАГА: АРИЛЖААНЫ БАНК, ТҮҮНИЙ ТӨРӨЛ, ОНЦЛОГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА МӨРДӨХ ЗАРЧМУУД :

- ✓ Хамгийн бага зардлаар хамгийн их ашиг олох
- ✓ Харилцан итгэлцлийн зарчим
- ✓ Өрсөлдөөний зарчим
- ✓ Эдийн засгийн хувьд бие даасан байх

БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУЛГУУР/ЯС МОД/:

- ✓ Үйлдвэрлэл, арилжаанаас чөлөөлөгдсөн мөнгөн капитал болох өөрийн хөрөнгө
- ✓ Бусад үйлдвэрлэгч, худалдаа үйлчилгээний байгуулагуудаас ялгаатай өвөрмөц үйлчилгээ, бүтээгдэхүүн
- ✓ Банкны удирдлага, ажилбараар мэргэшсэн ажиллах хүчин
- ✓ Үйлдвэрлэлийн нөхцөл болох тоног төхөөрөмж, барилга байгууламж, холбоо, сүлжээний техник хэрэгсэл гадаад дотоод мэдээлэл юм.

2. БАНКНЫ БАЙГУУЛЛАГА: АРИЛЖААНЫ БАНК, ТҮҮНИЙ ТӨРӨЛ, ОНЦЛОГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

БАНКНЫ ҮҮРГҮҮД /ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ-
АЖИЛБАР/:

1. Хадгаламж хуримтлуулах
2. Зээл олгох буюу хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хангах
3. Төлбөр тооцоо хийх
4. Мөнгө өсгөж үржүүлэх

Хөрвөх чадвартай санхүүгийн хэрэгслүүдийг шинээр бий болгох арилжааны банкны үйл ажиллагааг **МӨНГӨ ӨСГӨЖ ҮРЖҮҮЛЭХ** ГЭНЭ.

2. БАНКНЫ БАЙГУУЛЛАГА: АРИЛЖААНЫ БАНК, ТҮҮНИЙ ТӨРӨЛ, ОНЦЛОГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

БАНКНЫ ТӨРӨЛ, АНГИЛАЛ:

- Үүсгэн байгуулагдсан хэлбэрээрээ:
 - Хувьцаат
 - Хязгаарлагдмал хариуцлагатай
- Хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлөөр:
 - Төрийн өмчийн
 - Хувийн өмчийн
 - Холимог
- Үйл ажиллагаа явууулах хэлбэрээр:
 - Нийтлэг үйлчилгээтэй
 - Төрөлжсөн үйлчилгээтэй /үйлчилгээ, салбараар/

2. БАНКНЫ БАЙГУУЛЛАГА: АРИЛЖААНЫ БАНК, ТҮҮНИЙ ТӨРӨЛ, ОНЦЛОГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

БАНКНЫ ТӨРӨЛ, АНГИЛАЛ:

- ✓ Үйлчилгээний цөөн төрлийг дагнан эрхэлдэг, эсвэл тодорхой нэг салбарын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг банкийг төрөлжсөн банк гэнэ. /Ж-нь: Хөгжлийн банк/
- ✓ Нийгэм эдийн засгийн өргөн хүрээнд олон төрлийн үйлчилгээ эрхэлдэг банкийг нийтлэг үйлчилгээтэй банк гэнэ.
- ✓ Дүрмийн сангаа 100% төрийн өмчийн хөрөнгөөр бүрдүүлсэн банкийг төрийн өмчийн банк гэнэ.
- ✓ Хувийн секторын банк, хувийн компани, хоршоо, нөхөрлөл хувь хүний хувь хөрөнгөөр дүрмийн сангаа бүрдүүлсэн банкуудыг хувийн секторын банкууд гэж томъёолно.
- ✓ Харин хувийн секторын банкуудыг хувь нийлүүлсэн, хувийн гэж ангилна.

2. БАНКНЫ БАЙГУУЛЛАГА: АРИЛЖААНЫ БАНК, ТҮҮНИЙ ТӨРӨЛ, ОНЦЛОГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

БАНКНЫ ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА /ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ/:

1. Хадгаламжийн үйлчилгээ
2. Зээлийн үйлчилгээ
3. Төлбөр тооцооны үйлчилгээ
4. Төлбөрийн баталгаа, батлан даалт гаргах
5. Хөрөнгийн баталгаа гаргах үйлчилгээ
6. Үнэт металл, эрдэнийн чулуу худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах
7. Гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах
8. Үнэт зүйл хадгалах
9. Гадаад төлбөр тооцоо хийх
10. Үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах
11. Санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа
12. Зээл болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдах, худалдан авах

2. БАНКНЫ БАЙГУУЛЛАГА: АРИЛЖААНЫ БАНК, ТҮҮНИЙ ТӨРӨЛ, ОНЦЛОГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

СЗХ-НООС ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВЧ ЭРХЛЭХ ҮЙЛ
АЖИЛЛАГАА:


1. Санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх;
2. Итгэлцлийн үйлчилгээ;
3. Даатгалын зуучлагч;
4. Андеррайтерын үйлчилгээ;
5. Кастодиан;
6. Факторингийн үйлчилгээ;
7. Харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил, үйлчилгээ.

2. БАНКНЫ БАЙГУУЛЛАГА: АРИЛЖААНЫ БАНК, ТҮҮНИЙ ТӨРӨЛ, ОНЦЛОГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

БАНКИНД ХОРИГЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

- ✓ Ашиг олох зорилгоор банкны бус үйл ажиллагаа явуулах
- ✓ Харилцагчдын нууцыг задлах
- ✓ Санхүүгийн зах зээл дээр ноёрхох /зохион байгуулалттайгаар/
- ✓ Улс төрийн нам эвсэлд хандив өгөх

2. БАНКНЫ БАЙГУУЛЛАГА: АРИЛЖААНЫ БАНКНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



2. БАНКНЫ БАЙГУУЛЛАГА: АРИЛЖААНЫ БАНКНЫ ОРЛОГО, ЗАРДАЛ

ОРЛОГО:

- ✓ Зээл болон үнэт цаасны хөрөнгө оруулалтаас орох хүүний орлого
- ✓ Үйлчилгээний хөлс, шимтгэл г.м хүүний бус орлого
- ✓ Онцгой шинжтэй ердийн бус орлого

ЗАРДАЛ:

- ✓ Эх үүсвэр төвлөрүүлэхтэй холбоотой хүүний зардал
- ✓ Үйл ажиллагаатай холбоотой хүүний бус зардал
- ✓ Онцгой шинжтэй ердийн бус зардал

2. БАНКНЫ БАЙГУУЛЛАГА: ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШАЛГУУРУУД

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД:

/Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 7-р сарын 30-ны өдрийн 460 дугаар тушаалын хавсралт/

1. Өөрийн хөрөнгийн хүрэлцээний талаар:
2. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын талаар:
3. Зээлийн эрсдэлээс хамгаалах талаар:
4. Гадаад валютын эрсдэлээс хамгаалах талаар:

3. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА: ТӨРӨЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ОНЦЛОГ

1. Хадгаламж зээлийн байгууллага /depository savings institutions/
2. Даатгалын компани /insurance companies/
3. Тэтгэврийн сан / pension and retirement funds/
4. Хамтын сан / mutual funds/
5. Хөрөнгө оруулалтын банк / investment bank/
6. Эрсдэлт капиталын компани /Venture Capital Firms/
7. Хөрөнгө удирдлагын компани /Asset Management Firms/
8. Мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага /Information Services /

ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН БАЙГУУЛЛАГА /DEPOSITORY SAVINGS INSTITUTIONS/

- ✓ Хадгаламж зээлийн байгууллагад хамтын хадгаламжийн банк, хадгаламж зээлийн нийгэмлэг, зээлийн холбоод хамаардаг.
- ✓ АНУ-д хадгаламж зээлийн байгууллагууд нь арилжааны банкны хадгаламж татах, зээл олгох үйл ажиллагаатай нь өрсөлдөж хадгаламж, чекийн данс гарган сангийн хөрөнгөө өсгөх ба моргейж, хэрэглээний зээл олгох үйл ажиллагаанд төвлөрч ажилладаг.
- ✓ Манай улсад Банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, барьцаалан зээлдүүлэх газар зэрэг хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байна.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

NONBANK FINANCIAL INSTITUTION

ББСБ-ЫГ МОНГОЛ УЛСЫН БОЛОН ГАДААД УЛСЫН ХУУЛИЙН ЭТГЭЭД ЭРХЭЛЖ БОЛОХ БӨГӨӨД ДАРААХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЯВУУЛНА.

- Зээл;
- Факторингийн үйлчилгээ;
- Төлбөрийн баталгаа гаргах;
- Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах;
- Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ;
- Гадаад валютын арилжаа;
- Итгэлцлийн үйлчилгээ;
- Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх;
- Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх.
- Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА NONBANK FINANCIAL INSTITUTION

ББСБ ДАРААХЬ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХИЙГ ХОРИГЛОНО:

- Тусгай зөвшөөрөлд зааснаас өөр үйл ажиллагаа эрхлэх;
- Өөрийн үйл ажиллагааны талаар буруу ташаа зар сурталчилгаа хийх, мэдээлэл өгөх;
- Иргэн, хуулийн этгээдээс хадгаламж авах, хадгаламжийн данс нээх;
- Чек, карт, вексель зэрэг төлбөрийн хэрэгслээр хадгаламж авах;
- Банк бус санхүүгийн байгууллагын тайлан тэнцэлд тусгаагүй эх үүсвэрийг өөрийн үйл ажиллагаанд ашиглах.

ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШОО

SAVINGS AND LOAN ASSOCIATION

- ✓ Гишүүдийнхээ эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээг хангах зорилгоор гишүүддээ хадгаламж, зээлийн үйлчилгээг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үзүүлэх ардчилсан удирдлага, хамтын хяналт бүхий ашгийн төлөө бус хуулийн этгээдийг **Хадгаламж зээлийн хоршоо** гэнэ.
- ✓ ХЗХ нь тусгай зөвшөөрлийн үндсэн дээр мөнгөн хадгаламж, зээлийн үйл ажиллагааг эрхэлнэ.
- ✓ Монгол Улсын иргэн хадгаламж, зээлийн хоршоог үүсгэн байгуулж болох ба үүсгэн байгуулагчдын тоо 20 хүрсэн байх шаардлагатай байдаг.

ДААТГАЛЫН КОМПАНИ /INSURANCE COMPANIES/

- ✓ Даатгалын компани нь гэрээний үндсэн дээр даатгуулагчийн эрүүл мэнд, эд хөрөнгө, амь нас, ашиг сонирхолд эрсдэл учирсан тохиолдолд хохирлыг бүрэн буюу зарим хэсгийг төлөхөөр үүрэг хүлээдэг.
- ✓ Даатгалын компани нь хураамжаас бүрдсэн хөрөнгөө төлбөрийн чадвар сайтай хувьцаа, бонд, үл хөдлөх хөрөнгө оруулалт хийнэ.

Даатгалын компаниуд нь дараах төрөлтэй. Үүнд:

- Амьдралын даатгалын компани /Life Insurance Companies/
- Эд хөрөнгө, гэнэтийн осолын даатгалын компани / Property and Casualty Companies/

АМЬДРАЛЫН ДААТГАЛЫН КОМПАНИ /LIFE INSURANCE COMPANIES/

- ✓ Амьдралын даатгал нь ХҮII-ХҮIII үед Англид анх үүссэн бөгөөд далайн даатгалын нэмэлт хэлбэрээр хийгдэж эхэлсэн. Тэр үед хөлөг онгоц болон ачааны даатгалын зэрэгцээ хөлөг онгоцны ахмадын амь насыг урт хугацаанд даатгадаг байв. Улмаар далайчдыг далайн аяллын үед нас барахаас даатгадаг клуб Лондонгийн Ллойдсын цайны газар байгуулагдаж байсан.
- ✓ Япон улсад даатгал маш өндөр хөгжсөн бөгөөд дэлхийн амьдралын даатгалын нийт хураамжийн 32% нь тус улсад ноогддог байна. Японы амьдралын даатгалын маш томд тооцогдох Nippon Life Insurance Company нь 1882 онд байгуулагдсан эртний компаниудын нэг бөгөөд амьдралын даатгалын чиглэлээр мэргэшсэн, давхар даатгалыг голлон хийдэг. Дэлхий даяар нийт 40 мянган салбартай.

АМЬДРАЛЫН ДААТГАЛЫН КОМПАНИ /LIFE INSURANCE COMPANIES/

- ✓ Өндөр насны тэтгэвэрт гарах үед амьдралын одоогийн түвшинг хадгалах хэмжээний ирээдүйн тэтгэврийн хуримтлал бий болгох
- ✓ Тэжээгчээ алдсаны улмаас гэр бүлд учирч болох санхүүгийн эрсдэлээс хамгаалах
- ✓ Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар болон бүр мөсөн алдсан үед тэтгэмж авах
- ✓ Оршуулгын зардлаа нөхөх
- ✓ Мөнгөн хуримтлалтай болох
- ✓ Зээлдэгчийн зээлийн үлдэгдлийг даатгалын хамгаалалтад авах гэх мэт маш олон талын санхүүгийн хамгаалалтыг бий болгодог

ЭД ХӨРӨНГӨ, ГЭНЭТИЙН ОСОЛЫН ДААТГАЛЫН КОМПАНИ / **PROPERTY AND CASUALTY COMPANIES** /

Эд хөрөнгө гэнэтийн ослын даатгал нь амьдралын даатгалаас тохиолдох магадлал өндөр, гэнэтийн байдлаараа ялгаатай юм. Үүнд автомашины, галын, орон сууцны, хариуцлагын гэх мэт даатгалууд хамаарна.

ТЭТГЭВРИЙН САН

/ PENSION AND RETIREMENT FUNDS/

- Тэтгэврийн санг корпораци, улс, орон нутгийн засаг захиргаа эзэмшдэг.
- Ажил олгогч, даатгуулагчийн төлсөн НДШ-ээр сангаа бүрдүүлнэ. Корпорацийн үнэт цаасанд хөрөнгө оруулна. Өндөр настнуудад тэтгэвэр буюу тогтмол орлого-annuity хэлбэрээр хуваарилдаг.

ТЭТГЭВРИЙН САН / PENSION AND RETIREMENT FUNDS/

- Top 10 world largest Pension Fund for 2017

Rank	Fund	Country	Total Assets
1	Government Pension Investment	Japan	\$1,394,873
2	Government Pension Fund	Norway	\$575,527
3	ABP	Netherlands	\$320,356
4	National Pension	Korea	\$313,981
5	Federal Retirement Thrift	U.S.	\$281,359
6	California Public Employees	U.S.	\$220,638
7	Local Government Officials	Japan	\$199,549
8	Central Provident Fund	Singapore	\$159,789
9	Canada Pension	Canada	\$158,669
10	Employees Provident Fund	Malaysia	\$153,890

ХАМТЫН САН / MUTUAL FUNDS/

Өргөн хүрээний том хөрөнгө оруулалтуудад хамтарсан байдлаар хөрөнгө оруулах үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд зохион байгуулдаг хөрөнгө оруулалтын хэлбэрийг **хамтын сан** гэнэ.

Хамтын сан нь маш олон хөрөнгө оруулагчдаас мөнгө татаж

- Хувьцаа
- Бонд
- Мөнгөний захын богино хугацааны хэрэгслүүд
- Бусад үнэт цааснуудад хөрөнгө оруулалт хийдэг.

ХАМТЫН САН / MUTUAL FUNDS/

Хоёр төрлийн хамтын сан байдаг. Үүнд:

- Нээлттэй сан / Open – end funds/
- Хаалттай сан /Close – end funds/

Нээлттэй сан нь үнэт цаасаа бусдад худалдахаар байнга санал болгож, эрэлтийн хэмжээгээр гаргадаг бөгөөд үнэт цаасаа эргүүлэн худалдаг авах үүрэг хүлээдэг.

Хаалттай сан нь үүсгэн байгуулагчаас тогтоосон хөрөнгийн хэмжээнд багтаан нийтэд санал болгох хэлбэрээр үнэт цаас гаргаж, зах зээлийн үнээр худалддаг, өөрийн гаргасан үнэт цаасыг эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэггүй.

ХАМТЫН САН / MUTUAL FUNDS/

The 10 Largest Mutual Funds

Rank	Symbol	Fund Name
1	PTTRX	PIMCO:Tot Rtn;Inst
2	SPY	SPDR S&P 500 ETF
3	FDRXX	Fidelity Cash Reserves
4	VMMXX	Vanguard Prime MM;Inv
5	VTSMX	Vanguard T StMk Idx;Inv
6	VINIX	Vanguard Instl Indx;Inst
7	GLD	SPDR Gold
8	CJPXX	JPMorgan:Prime MM;Cap
9	VTSAX	Vanguard T StMk Idx;Adm
10	VFIAX	Vanguard 500 Index;Adm

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК / INVESTMENT BANK /

ААН, засгийн газарт үнэт цаас гаргаж хөрөнгө босгоход туслах зорилготой.

Мөнгийг аливаа төсөл, хэлцэлд татан оруулж энэ үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, санхүүгийн хэрэгслүүдийг анхдагч болон хоёрдагч зах зээлд худалдах, арилжих, зуучлах замаар бусдын хөрөнгийг өсгөх үйл ажиллагаа явуулдаг санхүүгийн байгууллага юм.

Хөрөнгө оруулалтын банк нь дараах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг. Үүнд:

- Компаниудад хөрөнгө босгоход зуучлах /underwriting/
- Хөрөнгө оруулагчдад ашигтай бизнес олоход зуучлах /investment management/

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК / INVESTMENT BANK/

- ✓ Компаниудад хөрөнгө босгоход зуучлах: ХО–ын банкуудын үндсэн үүрэг нь тухайн үнэт цаастай холбогдолтой бүх бичиг баримтуудыг цэгцлэх, холбогдох хуулийн зөвлөхүүдтэй ажиллах, цаашлаад төслийн маркетингийг хийх зэрэг бүх зохион байгуулалтын ажлыг хийх юм.
- ✓ Хөрөнгө оруулагчдад ашигтай бизнес олоход зуучлах:



Дэлхийн томоохон ХОБанкуудад: Bank of America Merrill Lynch, Barclays Capital, BNP Paribas, Citigroup, Credit Suisse, Deutsche Bank зэрэг орно.

ЭРСДЭЛТ КАПИТАЛЫН КОМПАНИ /VENTURE CAPITAL FIRMS/

Эрсдэлт капиталын компани нь Хөрөнгө оруулалтын банктай төстэй үйл ажиллагаа явуулдаг бөгөөд ялгаатай тал нь жижиг, анх гарч ирж буй компануудтай ажилладаг. Шинэ компаниудын менежерүүд туршлага багатай учир тэдэнд хөрөнгө оруулалтын зөвлөгөө байнга хэрэгтэй байдаг.

ХӨРӨНГӨ УДИРДЛАГЫН КОМПАНИ /ASSET MANAGEMENT FIRMS/

- Хөрөнгө удирдлагын компанийг хөрөнгө оруулалтын компани гэж ч нэрлэдэг.
- Хамтын сан, тэтгэврийн сан, даатгалын компаниуд, бусад хөрөнгө зуучлалын компани болон засгийн газарт зөвлөгөө өгөх, хөрөнгийг нь удирдах зэрэг хөрөнгө оруулалтын мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг.
- Хөрөнгө удирдлагын компани нь ихэнхдээ брокерын компани, даатгалын компани, банк мөн итгэлцлэлийн компани салбар байдлаар үйл ажиллагаагаа явуулдаг.

МЭДЭЭЛЛИЙН Ү“ЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА /INFORMATION SERVICES/

Мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч компаниуд нь санхүүгийн хэрэгсэл болон үйл ажиллагааны талаар мэдээлэл хүргэдэг ба ихэнхдээ төрөлжиж үйл ажиллагаагаа явуулдаг. Тухайлбал:

- ✓ Ү“нэт цаас -Moody’s, Standard & Poor’s;
- ✓ Даатгалын компани -Best’s;
- ✓ Хамтын сан -Lipper, Morningstar;
- ✓ Санхүүгийн мэдээлэл -Bloomberg, Reuters

СЕМИНАРЫН ДААЛГАВАР

- Лекцийг баяжуулж тэмдэглэл хөтлөх
- Төв банк болон банкны тухай хуулийг унших
- Банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулж буй хуулиудыг унших
- Баг болж хуваагдан арилжааны банкуудын үйл ажиллагааг харьцуулан ярилцах
- Арилжааны банкуудын үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтүүдийг сүүлийн 3 жилийн дундажаар харьцуулан дүгнэх

ДАРААГИЙН ЛЕКЦИЙН

СЭДЭВ

The Time Value of Money

Мөнгөний цаг хугацааны

ҮНЭ ЦЭНЭ